



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 21-ний
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 332 ХӨВСГӨЛ НУУР ОРЧМЫН БҮСИЙГ “ЭКО АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН БҮС” БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Аялал жуулчлалын тухай хуулийн 14.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас
ТОГТООХ нь:

1. Монгол Улсын цэнгэг усны 70 хувийн нөөцийг агуулдаг, байгалийн үзэсгэлэн цогцолсон Хөвсгөл нуурын экосистемийг хамгаалах, цаашид хүрээлэн буй орчинд ээлтэй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын бүс нутгийг “Эко аялал, жуулчлалын бүс” болгосугай.

2. “Хөвсгөл нуурын Эко аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэн хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан), Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Ганболд нарт тус тус даалгасугай.

4. Хөвсгөл нуурын “Эко аялал жуулчлалын бүс”-д ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, ус ашиглах гэрээ байгуулж, эрхийн бичиг аваагүй, усны тоолуургүй болон холбогдох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй, стандартын шаардлага хангаагүй иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Ганболдод үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын хилийн заагийг өргөтгөх асуудлыг судалж, Засгийн газарт танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад, “Эко аялал жуулчлалын бүс”-д хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчин үйл ажиллагааг явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг нь зогсоож, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн IY дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

Н.ЦЭРЭНБАТ

**ХӨВСГӨЛ НУУР ОРЧМЫН “ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
БҮСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ”
(2019-2023 он)**

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв		Хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа
		Эх үүсвэр	Төсөв (сая.төг)		
Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр					
1.	1,100 м ² талбай бүхий өдөрт 1000 гаруй хүн хүлээн авах хүчин чадалтай жуулчны мэдээллийн төв байгуулах	Азийн хөгжлийн банк	3,612.0	БОАЖЯ, Аймгийн ЗДТГ	2020-2021
2.	Аялагч жуулчдад зориулсан тохижилт, мэдээллийн самбаруудыг байршуулах, Дээд Модод булан-Жанхай, Чучу чиглэлд нийт 15 км, аяллын 2 жимийг жуулчдад зориулан тохижуулах	Азийн хөгжлийн банк	890.0	БОАЖЯ, Аймгийн ЗДТГ	2020-2021
3.	Ханх сумыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлуулах				
4.	Тогтвортой аялал жуулчлалын шалгуур үзүүлэлтийг боловсруулж, ногоон гэрчилгээг аж ахуйн нэгжүүдэд олгох	Азийн хөгжлийн банк	2,502.0	БОАЖЯ, Аймгийн ЗДТГ	2020-2023
5.	Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж буй нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдийг чадавхжуулах				

6.	Жуулчдад зориулсан гар урлал, жижиг дунд бизнесийг хөгжүүлэх, нутгийн иргэдийг дэмжих, нуурын эргийн 5 сумын иргэдэд олгож буй жижиг, дунд бизнесийг дэмжих зээлийн эргэлтийн санг үргэлжлүүлж, иргэдийг өргөнөөр хамруулах замаар өрхийн орлогыг тогтвортой дээшлүүлэх				
7.	Аялал жуулчлал эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, стандартын шаардлага хангаагүй, хууль, тогтоомжийг зөрчиж үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг нэн даруй зогсоож, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах арга хэмжээ авах	Улсын төсөв	18.0	БОАЖЯ, ЗТХЯ, ЭМЯ, МХЕГ	2019-2023
Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр					
8.	Хөвсгөл нуурын баруун эргийн аялал жуулчлалын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	150.0	ЭХЯ, БОАЖЯ	2020
9.	Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлд 37,9 км хатуу хучилттай зам тавих	Азийн хөгжлийн банк	23,909.0	ЗТХЯ, БОАЖЯ, Аймгийн ЗДТГ	2020-2023
10.	Хатгал, Ханх, Жанхай, Дээд Модот булан, Ардаг, Тойлог зэрэг цэгүүдэд 8,450 м ² талбайд 500 автомашины 8 ширхэг авто зогсоол байгуулах				
11.	Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх 2 цэгийг байгуулж, тохижуулах				
12.	Хөвсгөл нуурт усан замын тээврийн төв зогсоол байгуулах зураг төслийг боловсруулах	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	800.0	ЗТХЯ	2020-2021
Байгаль орчныг хамгаалах чиглэлээр					
13.	Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон нөөц даацын судалгаа хийх	Улсын төсөв	205.0	БОАЖЯ	2020

14.	Зохих зөвшөөрөлгүй газар ашиглаж буй иргэдийн судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтран зөрчил арилгуулах ажлыг зохион байгуулах	-	-	БОАЖЯ	2020-2021
15.	Хөвсгөл нуурын орчимд ургаж байгаа нэн ховор, ховор, ашиглалтад өртөмтгий, гоёл чимэглэлийн ургамлын цуглуулга бүхий ботаникийн цэцэрлэг байгуулж, ургамлын генийн санг хадгалах, ургамлын аялал жуулчлалыг хөгжүүлэх	Улсын төсөв	200.0	БОАЖЯ	2020-2022
16.	Хөвсгөл нуур орчмын аялал жуулчлалын бүсийн ховордон устаж байгаа нэн ховор, ховор болон ашигт ургамлын үрийн болон эх ургамлын плантаци байгуулж үрийн, эх ургамлын нөөц бий болгож Хөвсгөл нуурын эрэг орчмын талхлагдсан газар нутгийг унаган ургамлаар нөхөн сэргээх	Улсын төсөв	200.0	БОАЖЯ	2020-2023
17.	Эко бүсийн хил заагаар агаарын чанарыг сайжруулах бүс тогтоож, бүсийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Улсын төсөв	35.0	БОАЖЯ	2020
18.	Хөвсгөл нуурын орчимд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Улсын төсөв	-	БОАЖЯ	2020-2021
19.	Хоггүй монгол аяны хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулж, идэвхжүүлэх	Улсын төсөв	-	БОАЖЯ	2020
20.	Нуурын эрэг орчмын хөрсний чанарын судалгаа хийх	Улсын төсөв	75.0	БОАЖЯ	2020
21.	Нуур болон нуурын эрэг орчмын биологийн олон янз байдлын судалгаа хийх	Улсын төсөв	80.0	БОАЖЯ	2020
22.	Хөвсгөл нуурын төлөв байдлыг үнэлэх, Судалгаа хийж, живсэн тээврийн хэрэгсэл г.м аюултай хог хаягдлын байршлыг тодорхойлох		5,748.0	БОАЖЯ	2020-2021
23.	экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх цогц төсөл хэрэгжүүлэх	Аюултай хог хаягдлыг нуурын гүнээс гаргах, устгал хийх	8,197.0	БОАЖЯ	2021-2022
24.		Хөвсгөл нуурын цогц судалгаа, шинжилгээ хийж, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах	4,074.0	БОАЖЯ	2020-2023

25.	Нуурын онцгой, энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх, ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгжүүдийг бүрэн тоолууржуулах ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	80.0	БОАЖЯ	2020
26.	Хүрээлэн буй орчинд ээлтэй хатуу хог хаягдлыг дарж булшлах технологи бүхий 2 цэгийг Хатгал тосгон, Ханх суманд байгуулах	Азийн хөгжлийн банк	4,637.0	БОАЖЯ Аймгийн ЗДТГ	2020-2023
27.	Шингэн хог хаягдлыг нөөцлөх нийт 52,500 м ³ талбай бүхий 2 цэгийг Хатгал тосгон, Ханх суманд байгуулах				
28.	Орон нутгийг шингэн, хатуу хог хаягдлыг зөөвөрлөх зориулалтын тээврийн 4 хэрэгслээр хангах				
29.	түр отоглох 22 цэг болон автомашины зогсоолд 29 ариун цэврийн байгууламж байгуулах				
30.	Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт олгогдсон газрын байр зүйн зураглал, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, засварлан, Улсын кадастрын нэгдсэн мэдээллийн санд холбох ажлыг зохион байгуулж цаасан болон цахим архивыг бий болгох	Улсын төсөв	100.0	БОАЖЯ	2020-2021
31.	Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газрыг Хүн ба шим мандлын хөтөлбөрт бүртгүүлж, олон улсын сүлжээнд хамруулах	Улсын төсөв	30,0	БОАЖЯ	2020-2022
Гадаад улсын төсөл, хөтөлбөр		35,550.0 (гучин таван тэрбум таван зуун тавин сая)			
Улсын төсөв		19,992.0 (арван есөн тэрбум есөн зуун ерэн хоёр сая)			
Нийт төсөв		55,542.0 (тавин таван тэрбум таван зуун дөчин хоёр сая)			